

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340.50, 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Хөл хамгаалах хэрэгсэл. Ажлын тусгай гутал	MNS 5623:20XX
Occupational safety and health. Personal protective equipment. Foot protection. Safety footwear	MNS 5623:2006-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь хүний хөл механик биет, химийн бодис, цахилгаан, ус чийг, халуун хүйтний нөлөөлөлд өртөх эрсдэл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

MNS 4931, Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал

3 Нэр, томъёо тодорхойлолт

3.1

Ажлын гутал

Механик биет, химийн бодис, цахилгаан, ус чийг, онцгой нөхцөлд тохиолдож болзошгүй осол гэмтлээс хөлийг хамгаалах, хүний эрүүл мэндэд тохирсон зориулалтын хэрэгсэл

4 Хөл хамгаалах хэрэгслийн ангилал

4.1 Хөл хамгаалах хэрэгслийг зориулалтаар нь дараах төрөлд ангилна.

4.1.1 Механик биетээс хамгаалах

4.1.2 Ус, чийгээс хамгаалах

4.1.3 Химийн бодисоос хамгаалах

4.1.4 Тусгай зориулалтын ажлын гутал /онцгой осол уршгийг арилгах үед хэрэглэх/
Тайлбар: Халуун, хүйтнээс хамгаалах гутал энэ стандартад ороогүй болно.

5 Хөл хамгаалах хэрэгслийн төрөл

5.1 Хөл хамгаалах хэрэгслийг хийцээр нь дараах төрөлд ангилна.

5.1.1 Урт түрийтэй

5.1.2 Хагас түрийтэй

5.1.3 Богино түрүүтэй

5.1.4 Түрүүгүй

5.1.5 Улавч, углааш

6 Ерөнхий зүйл

6.1 Зорилго

Энэ стандартын зорилго нь ажлын байранд ажиллаж буй хүний хөлийг механик биет, химийн бодис, цахилгаан, ус чийг, халуун хүйтний нөлөөллөөс хамгаалах зориулалтын гуталд тавих шаардлагыг тогтооход оршино.

6.2 Ерөнхий шаардлага

6.2.1 Хөл хамгаалах хэрэгсэл нь MNS 4931, Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал стандартын шаардлагыг хангасан байна.

6.2.2 Хөл хамгаалах хэрэгсэл нь зориулалтын шаардлага хангасан, өнгө үзэмжтэй, бат бөх, эдэлгээнд тэсвэртэй, өмсөхөд хөлд эвтэй, зориулалтын дагуу ашиглахад тохирсон байна.

6.2.3 Төмөр эсвэл зориулалтын материалаар хийсэн хоншоорын хамгаалалттай, ул тусгаарлагчтай, хүний арьсанд хүрэх хэсгүүд зөөлөн материалаар хийсэн, шагай хамгаалагчтай байна.

6.2.4 Халтирдаггүй ултай, ул нь нягтаршил, уян хатан байдлаа хадгалж олон удаагийн нугаралтыг даах чадвартай, эдэлгээнд тэсвэртэй байна.

6.2.5 Эрүүл ахуйн шаардлага хангасан, хүний арьсанд хор нөлөөгүй, агаар нэвтрүүлдэг, цэвэрлэхэд хялбар байна.

6.2.6 Өсгий хэсэг нь 20 джоулаас дээш доргион шингээх шок шингээгчтэй байна.

6.2.7 Статик цахилгаан дамжуулдаггүй байна.

6.2.8 Хөл хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт нь “А” хавсралтад заасантай тохирч байна.

6.3 Тусгай шаардлага

6.3.1 Механик биетээс хамгаалах ажлын гутлын тусгай шаардлага

6.3.1.1 Механик биетээс хамгаалах ажлын гутлын ул болон ар хэсэг нь төмөр хамгаалалттай, хоншоор нь 200 джоулын энергийн цохилтыг тэсвэрлэдэг байна.

6.3.1.2 Гутлын ул нь зузаан, халтирдаггүй, хугардаггүй шахмал резинэн материалаар, түрий хэсэг нь ширээр хийсэн байна.

6.3.1.3 Төмөр хоногууд нь зэвэрдэггүй, механик үртэс, тоос, шороо орохгүй үргэлж хэлтэй, зуузайны хатуулгатай, давхар оёдолтой байна.

6.3.2 Ус, чийгээс хамгаалах ажлын гутлын тусгай шаардлага

6.3.2.1 Ус чийгээс хөл хамгаалах гутал нь шахмал резинэн материалаар ул болон түрийг оёдолгүй хийсэн байна.

6.3.2.2 Ул нь зуурамтгай, нугаралт үүсэхгүй байна.

6.3.2.3 Ус, чийгтэй орчинд олон цагаар ажиллах үед хөл чийгтэх, хөлөрч гулсах эрсдэлийг багасгах үүднээс дотрыг чийг гадагшлуулах чадвартай, хөлийн арьсанд харшил өгөхгүй материалаар хийсэн байна.

6.3.3 Химийн бодисоос хамгаалах ажлын гутлын тусгай шаардлага

6.3.3.1 Материал нь полибутанкарбонат /PVC/ материалаар ул ба түрийг оёдолгүйгээр хийсэн, гутлын дотор нь чийг татахгүй, химийн ууршилтаас хамгаалсан, хөлийн арьсанд харшил өгөхгүй материалаар хийсэн байна.

6.3.3.2 Ул нь химийн бодисын нөлөөгөөр уусах, хагарахгүй, зөөлрөхгүй, гулсахгүй, нугаралт үүсэхгүй байна.

6.3.4 Тусгай зориулалтын ажлын гутлын тусгай шаардлага

6.3.4.1 Галд тэсвэртэй мөнгөлөг материалаар бүрж оёсон.

6.3.4.2 Өндөр температурт үйлдвэрлэсэн тусгай зориулалтын резинэн ултай байна.

6.3.4.3 Хурууны ган хамгаалалттай

6.3.4.4 Цахилгаан гүйдлийг дамжуулахгүй байх

7 Хөл хамгаалах хэрэгслийг шалгах, хэрэглэх

7.1 Хөл хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт, хөдөлмөрийн нөхцөлийн зохицолтыг шалгасны дараа гутлаа өмсөж, ажил гүйцэтгэхэд гутлын дотор хөл хэр эвсэлтэй байгааг шалгаад ажлаа эхэлнэ.

7.2 Тусгай зориулалтын ажлын гутлыг шалгах ба хэрэглэх

7.3 Тусгай зориулалтын ажлын гутлыг энэхүү стандартын 5.3.4-д заасны дагуу техникийн үзүүлэлт, хөдөлмөрийн нөхцөлийн зохицолтыг шалгасны дараа ажлаа эхэлнэ.

8 Хадгалах нөхцөл

Хуурай орчинд, тасалгааны температурт баглаа боодолтой нь хадгална.

9 Анхаарах зүйл

9.1 Ажлын гутлын техникийн үзүүлэлт, тухайн ажилтны хөдөлмөрийн нөхцөлд бүрэн тохирч байгаа эсэх

9.2 Ажлын гутал нь техникийн бичиг баримт үзүүлэлттэйгээ бүрэн тохирч буй эсэх

9.3 Ашиглах, хэрэглэх арга нь энэхүү стандартын дагуу явагдаж байгаа эсэхийг байнга шалгаж байна.

ТӨГСӨВ.

А Хавсралт
(мэдээллийн)

Хүснэгт А.1

**Ажлын гутал болон тусгай зориулалттай ажлын гутлын
техникийн үзүүлэлт**

№	Зориулалт	Техникийн үзүүлэлт
1	Механик биетээс хөл хамгаалах гутал	Хурууны ган хамгаалалтай, 200 хүртэлх джоулын механик биетийн цохилтыг хамгаалах Гутлын ул нь зузаан, халтирдаггүй, хугардаггүй шахмал резинэн материалаар, түрий хэсэг нь ширээр хийсэн байна. Хэмжээ нь 36 см-ээс 47 см байна. Хатуулгатай зуузай Давхар оёдолтой
2	Ус чийгээс хөл хамгаалах гутал	Ус чийгээс хөл хамгаалах гутал нь шахмал резинэн материалаар ул болон түрийг оёдолгүй хийсэн байна. Хэмжээ нь 36 см-ээс 47 см байна. Ул нь зуурамтгай, нугаралт үүсэхгүй
3	Химийн бодисоос хөл хамгаалах гутал	Полибутанкарбонат /PVC/ материалаар ул ба түрийг оёдолгүйгээр хийсэн байна. Хэмжээ нь 36 см-ээс 47 см байна. Ул нь зуурамтгай, нугаралт үүсэхгүй
4	Тусгай зориулалтын ажлын гутал	Өндөр температурт үйлдвэрлэсэн тусгай зориулалтын резинэн ултай Хурууны ган хамгаалалттай Галд тэсвэртэй мөнгөлөг материалаар бүрж оёсон